



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Г 2020 онд экспортлох, импортлох стратегийн
хүнсний тоо, хэмжээний тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 18 дугаар зүйлийн 18.5-д заасныг үндэслэн Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөөс ЗӨВЛӨМЖ болгох нь:

Монгол Улсын 2020 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний тоо хэмжээг дор дурдсан хэмжээнд хүртэл тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд зөвлөсүгэй.

Нэг. Экспорт

Шинэ, хөргөсөн, хөлдүү махны хувьд:

1.1 Үхрийн мах – 8300 тонн (найман мянга гурван зуу);

1.2 Адууны мах – 27900 тонн (хорин долоон мянга есөн зуу);

1.3 Хонь, ямааны мах экспортлох тоо, хэмжээнд хязгаар тогтоохгүй байх.

Бусад улстай байгуулсан гэрээ хэлэлцээрийн хүрээнд дулааны аргаар боловсруулсан махны хувьд:

1.4 Дулааны аргаар боловсруулсан хонины мах – 6600 тонн (зургаан мянга зургаан зуу);

1.5 Дулааны аргаар боловсруулсан ямааны мах – 12000 тонн (арван хоёр мянга);

1.6 Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах - 8000 тонн (найман мянга);

1.7 Дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн (хиам, зайдас, лаазалсан, хатаасан г.м)-ийг экспортлох тоо хэмжээнд хязгаар тогтоохгүй байх.

Хоёр. Импорт

2.1 Үхрийн мах – 500 тонн (таван зуу);

2.2 Хүнсний улаанбуудай 60,000 тонн (жаран мянга);

2.3 Үрийн улаанбуудай 15,000 тонн (арван таван мянга);

2.4 Хуурай сүү 4,000 тонн (дөрвөн мянга).

Гурав, Савласан цэвэр ус, шингэн сүү, улаанбуудайн гурил импортлох, экспортлох тоо хэмжээг 2020 онд тогтоох шаардлагагүй гэж үзэв.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



У ХҮРЭЛСҮХ